



**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/32

Улаанбаатар хот

“Хоггүй Хан-Уул 2022” аян хэрэгжүүлэх  
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.5 дахь заалт, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/08 дугаар тушаалыг үндэслэн Хан-Уул дүүргийн Засаг Даргын “Хоггүй Хан-Уул 2022” аяны хүрээнд зохион байгуулах бүх нийтийн их цэвэрлэгээний А/56 тоот захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. “Хоггүй Хан-Уул 2022” аяны хүрээнд хийх их цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.


Ажлын хэсгийн дарга:	Т.Дэлгэрмаа -	Аж ахуйн албаны дарга
Нарийн бичиг:	Г.Эрдэнэхүү -	Аж ахуйн нярав
Гишүүд:	Б.Лувсанням -	НЭМ-ийн орлогч дарга
	Д.Молор-Эрдэнэ -	Амбулаторийн эрхлэгч
	З.Уранчимэг -	ХЭТ-ийн эрхлэгч

2. “Хоггүй Хан-Уул 2022” бүх нийтийн их цэвэрлэгээний хуваарийг хавсралтаар баталсугай.

3. “Хоггүй Хан-Уул 2022” бүх нийтийн их цэвэрлэгээнд шаардлагатай багаж, бээлий, хог хийх уут шуудайгаар ханган ажиллахыг аж ахуйн нярав /Г.Эрдэнэхүү-д, их цэвэрлэгээ хийсэн тухай тайлан, илтгэх хуудсыг тухайн өдрийн 16:00 цагаас өмнө илгээж байхыг бичиг хэргийн ажилтан /О.Дулмаа/-д үүрэг болгосугай.

4. ХУД-ийн Засаг Даргын захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж, нийт эмч ажилчдаа бүрэн хамруулахыг тасаг нэгжийн дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Э.БОДЬЦЭЦЭГ

3 170 7031725

Хан-Уул эрүүл мэндийн төвийн даргын  
2022 оны 05 дугаар сарын 06 ны өдрийн  
01/32 -р тушаалын нэгдүгээр хавсралт

“ХОГГҮЙ ХАН-УУЛ 2022” АЯНЫ ХҮРЭЭНД ИХ ЦЭВЭРЛЭГЭЭ ХИЙХ ТАСАГ  
НЭГЖИЙН ХУВААРЬ

№	Тасаг нэгж, түрээслэгч байгууллага	Цэвэрлэгээ хийх талбай	Хариуцан хяналт тавих албан тушаалтан
1	Захиргаа, аж ахуйн тасаг	ЭМТөвийн барилгын баруун тал, хүлээн авах тасгийн үүд хэсэг	Аж ахуйн албаны дарга
2	Нийгмийн эрүүл мэндийн тасаг	ЭМТөвийн барилгын зүүн тал, төв үүд хэсэг	НЭМОрлогч дарга
3	Поликлиник	ЭМТөвөөс зүүн тийш автобусны буудал хүртэлх хэсэг, замын урд тал	Поликлиникийн эрхлэгч
4	Хэвтэн эмчлүүлэх тасаг	ЭМТөвөөс зүүн тийш автобусны буудал хүртэлх хэсэг, замын хойд тал	ХЭТ-ийн эрхлэгч
5	Энхжин лаборатори /Монба Энот ХХК	Өөрийн эзэмшиж буй талбай, дэмжих төвийн үүд, коридор	Лабораторийн эрхлэгч
6	Эмийн сан /Хишигт шандас ХХК/	Өөрийн эзэмшиж буй талбай, эрүүл мэндийн төвийн үүд фистул	Эмийн сангийн эрхлэгч
7	Гал тогоо /Хатан цох ХХК/	Өөрийн эзэмшиж буй талбай, хүлээн авахын хэсэг	Ахлах тогооч